



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41000 Зуунмод, Төв аймаг  
Утас: 70272248, Факс: 70272582, e-mail: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn)

2018. 02. 23 № 1/63

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ТӨВ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ГАЗРЫН ДАРГА С.МОНХТУЯА ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус салбарын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бodoх бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглувансан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохицтой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бodoх бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бodoх бүртгэл хөтөлнө” гэж заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бodoх бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бodoх бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ



ТӨВ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2017  
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Аудитын тайлан**

Төв аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал  
Утас: 70272582, 99089008  
И-мейл: khj- 616@yahoo.com

Хавсралт 1: Агуулга  
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ  
Хавсралт 3: Менежментийн захидал  
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан  
Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудитын менежер: О.Амаржаргал  
Утас: 70273465, 88039862  
И-мейл: amaraa\_tuv@yahoo.com

Аудитор: О.Сосор  
Утас: 70273204, 97020991  
И-мейл: Sosor@yahoo.com.sg

Аймгийн Аудитын газрын хаяг:  
Төв аймаг Зуунмод сум 1-р баг  
Төрийн байгууллагуудын ордон  
Цахим хуудас: tuv@audit.gov.mn

## **АГУУЛГА**

---

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланда хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

### Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн наймдугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн арван тавдугаар зүйлийн 15.1.2 дахь заалт, арван наймдугаар зүйлийн 18.2 дахь заалтыг үндэслэн Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хурээнд Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /ТӨА-2018/206/СТА-ТШЗ/ аудит хийлгээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хурээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын төсвийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, Нийцлийн аудитын 4200 стандарт болон түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 02 дугаар сарын 08-наас 2018 оны 02 дугаар сарын 14-нийг хуртэл хийхээр төлөвлөн Төв аймаг дахь Төрийн аудитын газрын санхүүгийн аудитын багийн гишүүн аудитор О.Сосор хэрэгжүүлэв.

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2017 оны төсвийн санхүүгийн тайланг 2018 оны 01 дүгээр сарын 24-нд Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Төв аймаг дахь Төрийн аудитын газар аудитыг 2018 оны 02 дугаар сарын 13-наас 2018 оны 02 дугаар сарын 21-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 02 дугаар сарын 25-нд Төв аймгийн Эрүүл мэндийн газрын удирдлагад гардуулна.

### Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Эрүүл мэндийн тухай хууль, Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль хурээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт ороогүй бөгөөд харин Эрүүл мэндийн тухай хуулинд өөрчлөлт орсон.

### Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1-д “Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндсэн зарчмыг тодорхойлж, иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ авах эрхийг хангахад оршино” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 23 дугаар зүйлд “Эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоо нь хүн амын эрүүл мэндийг сайжруулах, хүн амд тэгш, хүртээмжтэй, чанартай эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ”, 24 дүгээр зүйлийн 1-д “Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний санхүүжилт нь улсын төсөв, иргэний эрүүл мэндийн даатгал, Засгийн газрын тусгай сан болон аж ахуйн нэгж, байгууллага, хамт олон, иргэний хандив, эрүүл мэндийн байгууллагын төлбөртэй тусlamж, үйлчилгээ, бусад үйл ажиллагааны орлого, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэнэ” мөн Монгол улсын Засгийн газрын

агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн арван хоёрдугаар зүйлийн 12.1-д “агентлагийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.38 –д “төсвийн шууд захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваариласан чиг үүргийн төсвийг төлөвлөх хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг гэж заасны дагуу Эрүүл мэндийн газрын дарга төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг Эрүүл мэндийн яамнаас баталж Аймгийн төрийн сангаас олгож байна.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Эрүүл мэндийн тухай хууль, Төсвийн тухай хуулиуд бүрэн хэрэгжсэн. Төсвийн тухай хуулийн 16.5-аар Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар хэрэгжүүлэх бүрэн эрхийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх гэсэн заалт, мөн МУЗГ-ын 2014 оны 327 дугаар тогтоолоор Мэргэжлийн хяналтын газрын санхүүгийн хяналт, шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлдэг орон тоог аймгийн Санхүүгийн хяналт аудитын албанад шилжүүлсэнтэй холбогдуулан аймгийн Санхүүгийн хяналт аудитын албыг аймгийн Засаг даргын 2015 оны А/52 дугаар захирамжаар нийт 7 орон тоотойгоор байгуулан ажиллаж эхэлсэн байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

**Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:**

Аудит хийхэд Нягтлан бodoх бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Төв аймгийн Эрүүл мэндийн газрын төсвийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансадад түүвэрчилсэн байдлаар 4 аудитын сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бodoх бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТШЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бodoх бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна. ОУЫН стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, бүртгэлийн програм уялдсан байна.

Төсвийн захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Төсвийн захирагчийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

**Дотоод хяналт:**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн програмаар боловсруулж байна. Эдгээр журам нь УСНББОУС-тай нийцсэн байна.

**Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:**

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Эрүүл мэндийн яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Тайлант онд батлагдсан төсөөв улсын төсвөөс авах санхүүжилт 1920197.3 мянган төгрөгөөр батлагдсан. Гүйцэтгэлээр улсын төсвөөс авах санхүүжилт 1920197.3 мянган төгрөгөөр, УИХ-ын гишүүний тойротоо хуваариласан санхүүжилт 4200.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 1042256.0 мянган төгрөг, төсвийн урамшуулалт 3312.8 мянган төгрөг, ЭМЯамнаас 15500.0 мянган төгрөг, Аймгийн Засаг даргын захирамжаар 10785.8 мянган төгрөг, нийт орлого эх үүсвэр 2996390.5 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлсэн. Үүнээс урсгал зардалд 2991789.7 мянган төгрөг зарцуулж, 4600.8 мянган төгрөгийг Сангийн яаманд төвлөрүүлсэн байна.

**Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:**

Аудитын төлөвлөгөөний дагуу данс бүрээр нийт 4 горим, сорилт гүйцэтгэв.

Үр дагавар Эдгээр эрсдэлүүд нь төсвийг хэмнэлтгүй зарцуулсан, төсвийг үр ашиггүй зарцуулсан, төсвийн зориулалтыг зөрчсөн, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сулруулж цаашид хөрөнгийг үрэгдүүлэх, чанар байдлыг алдагдуулах, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг бууруулсан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг муу үр дагаварт хүрч болзошгүй байна.

**Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:**

Эрүүл мэндийн газрын төсвийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, завсрыйн аудит хийгдсэн тул 2017 оны 11, 12-р саруудын ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

**Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг бус 4373.4 мянган төгрөгийн алдаа илэрсэн байна. Үүнд:

1. 2017 оны 12-р сард 6358.0 мянган төгрөгийн шатахуун орлогодож, 3348.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулж, 2017.12.31-ны байдлаар 4373.4 мянган төгрөгийн шатахууны үлдэгдэлтэй гарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7.7 дахь заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 7.7 "төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэсэн заалтыг баримтлан ажиллах зөвлөмж өгөв.

2. Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэхдээ тооцооны үлдэгдлийн баталгааны тооцооны баримтын жагсаалтыг хөтлөөгүй Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэхдээ Санхүү эдийн засгийн сайд, ҮСГ-ын даргын 2002 оны 6-р сарын 18 ний өдрийн 171/111 тоот тушаалаар батлагдсан анхан шатны маягт хөтлөх зааврыг зөрчсөн.  
Шийдвэрлэсэн нь: Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэхдээ Санхүү эдийн засгийн сайд, ҮСГ-ын даргын 2002 оны 6-р сарын 18 ний өдрийн 171/111 тоот тушаалаар батлагдсан тооцооны үлдэгдлийн баталгааны тооцооны баримтын жагсаалтыг баримтлан ажиллах зөвлөмж өгөв.

тайлбар:

Аудитын явцад залруулах материаллаг алдаа тогтоогдоогүй болно.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч аудитын хугацааны шалтгаанаас аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй байж болох дээрх анхаарал татахуйц асуудалд дурьдагдсан асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын төсвийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 4373.4 мянган төгрөгийн зөрчилд алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өглөө.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын төсвийн 2016 оны санхүүгийн тайланд Төв аймгийн Аудитын газраас хийсэн аудитаар өгсөн 4 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:

Зөрчилгүй санал дүгнэлт

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 7 хуудсыг хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

О.АМАРЖАРГАЛ

О.СОСОР



ТӨВ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР



2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Менежментийн захидал**

**Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс**

**Асуудал 1**

**Бараа материалын талаар 3**

**Асуудал 2**

**Авлага, өглөгийн талаар 4**

## **Менежментийн захидал**

**Төв аймаг дахь Төрийн аудитын газар** нь аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Төсвийн шууд захирагчид зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Төсвийн захирагчийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## **Асуудал 1 Бараа материалын талаар**

**Тэргүүлэх ач холбогдол**

### **АГ-ын ажиглалт**

2017 оны 12-р сард 6358.0 мянган төгрөгийн шатахуун орлогодож, 3348.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулж, 2017.12.31-ны байдлаар 4373.4 мянган төгрөгийн шатахууны үлдэгдэлтэй гарсан байна. Төсвийн тухай хуулийн 7.7 дахь заалтыг зөрчсөн.

Төсвийн тухай хуулийн 7.7 "төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэсэн заалтыг баримтлан ажиллах.

### **Эрсдэлүүд**

Хууль тогтоомж журам заавар зөрчсөн эсэх.

### **Үйлчлүүлэгчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

### АГ-ЫН АЖИГЛАЛТ

Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэхдээ тооцооны үлдэгдлийн баталгааны тооцооны баримтын жагсаалтыг хөтлөөгүй зөрчил илэрсэн. Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэхдээ Санхүү эдийн засгийн сайд, ҮСГ-ын даргын 2002 оны 6-р сарын 18-ний өдрийн 171/111 тоот тушаалаар батлагдсан тооцооны үлдэгдлийн баталгааны тооцооны баримтын жагсаалтыг баримтлан ажиллаагүй зөрчил илэрсэн.

### АГ-ЫН ЗӨВЛӨМЖҮҮД

Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэхдээ Санхүү эдийн засгийн сайд, ҮСГ-ын даргын 2002 оны 6-р сарын 18 ний өдрийн 171/111 тоот тушаалаар батлагдсан тооцооны үлдэгдлийн баталгааны тооцооны баримтын жагсаалтыг баримтлан ажиллах.

### ЭРСДЭЛҮҮД

Хууль тогтоомж журам заавар зөрчсөн эсэх.

### ҮЙЛЧЛУУЛЭГЧИЙН ХАРИУ

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

### МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Ц.ХИШИГЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР:

О.АМАРЖАРГАЛ

БЭЛТГЭСЭН АУДИТОР:

О.СОСОР

